**НИЙСЛЭЛИЙН**
**НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 02 сарын 13 өдөр Дугаар А/12 Улаанбаатар хот

**Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн замналд зогсоол нэмэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/536 дугаар захирамжаар баталсан "Нийтийн тээврийн бодлогын газрын дүрэм"-ийн 4.1.2.1, 4.1.2.2, 7.1.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж, иргэдийн эрэлт хэрэгцээг хангах үүднээс Баянзүрх дүүргийн 27 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай Дунд дарь эх (зүүн) зогсоолыг шинээр нээж Ч:10 "Гадна тойруу – Баянмонгол хороолол – ТЭЦ - 3" чиглэлийн замналыг нэгдүгээр хавсралтаар, Ч:25 "Тоосгоны үйлдвэр – Их тойруу - Дүүхээ дэлгүүр" чиглэлийн замналыг хоёрдугаар хавсралтаар, Ч:26 "Тоосгоны үйлдвэр – Ботаник - Жанжин клуб" чиглэлийн замналыг гуравдугаар хавсралтаар, Ч:29А "Сэлбэ амралт – Сансар – Хөгжим бүжгийн коллеж - Өргөө амаржих газар" чиглэлийн замналыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлалсугай.

2.Дээрх чиглэлүүдийн өөрчлөлтийг программ хангамжид оруулж, нэгдсэн даалгаварт тусган үйлчилгээг 2026 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс эхлүүлэхийг Тээврийн бодлого, судалгааны хэлтэс (Д.Баясгалан)-т, тухайн чиглэлийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Зорчигч тээврийн хэлтэс (Х.Баасансүрэн)-т, ажлын гүйцэтгэлийг үндэслэн холбогдох санхүүжилтийг тооцож ажиллахыг Санхүү, аж ахуйн хэлтэс (Б.Бадамдорж)-т, үйлчилгээг батлагдсан замналын дагуу явуулахад хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Мягмар)-т, иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/24 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт, 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/35 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/154 дүгээр тушаалын


17260201/9

нэгдүгээр хавсралт, 2023 оны 05 дугаар сарын 29-ний А/61 дүгээр тушаалын хавсралтыг тус тус хүчингүй болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т үүрэг болгосугай.

ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

ХТҮ6986 3024050915 2117428

[illegible]

D:\alban khereg\явсан бичиг-2026\Монгол бичиг-A4 тушаал.docx

1726020149

ᠬᠣᠷᠢᠨ ᠳᠥ-(ᠭᠤᠷᠪᠠᠳᠤᠭᠠᠷ᠂ ᠨᠢ) ᠬᠡᠯᠡᠯᠴᠡᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠤᠭᠤᠴᠠᠭ᠎ᠠ ᠨᠢ ᠬᠣᠶᠠᠷ ᠲᠠᠯ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠭᠠᠷ ᠤᠰᠤᠭ ᠵᠢᠷᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠢ ::
ᠪᠣᠯᠤᠨᠠ ::

ᠭᠠᠷ ᠤᠰᠤᠭ ᠵᠢᠷᠤᠭᠰᠠᠨ : ᠬᠤᠪᠢ ᠬᠦᠮᠦᠨ

Нийтийн тээврийн газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/12 дугээр тушаалын ..1.. дүгээр хавсралт

# Ч:10 "ГАДНА ТОЙРУУ – БАЯНМОНГОЛ ХОРООЛОЛ – ТЭЦ-3"

**Нийтийн Тээврийн Газар**




## Тайлбар :

| | |
|---|---|
| Эргэлтийн урт: | 27,9 км |
| Эргэлтийн хугацаа: | 85 мин |
| Зогсох буудлын тоо: | 41 |
| Дайран өнгөрөх уулзварын тоо: | 12 |

- ТЭЦ-3
- Сансар ШТС
- 120 мянгат
- Хөдөлгөөний чиглэл
- Энхтайваны өргөн чөлөө

- Эцсийн зогсоол
- Хоёр чиглэлдээ зогсдог зогсоол
- Нэг чиглэлдээ зогсдог зогсоол
- Гудамжны нэр

- 35° Газрын налуугийн градус /уруу/
- 35° Газрын налуугийн градус /өгсүүр/
- Гэрлэн дохио
- Гүүр
- Аюулгүйн тойрог

Нийтийн тээврийн газрын 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/12 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

# Ч:25 "ТООСГОНЫ ҮЙЛДВЭР – ИХ ТОЙРУУ – 3,4-Р ХОРООЛОЛ"

**Нийтийн Тээврийн Бодлогын Газар**




## Тайлбар :

| | |
|---|---|
| Эргэлтийн урт: | 26 км |
| Эргэлтийн хугацаа: | 91 мин |
| Зогсох буудлын тоо: | 41 |
| Дайран өнгөрөх уулзварын тоо: | 11 |

- Тоосгоны үйлдвэр эцэс — Эцсийн зогсоол
- Баянбүрд — Хоёр чиглэлдээ зогсдог зогсоол
- Парадокс — Нэг чиглэлдээ зогсдог зогсоол
- Хөдөлгөөний чиглэл
- Энхтайваны өргөн чөлөө — Гудамжны нэр
- /35° Газрын налуугийн градус /уруу/
- \35° Газрын налуугийн градус /өгсүүр/
- Гэрлэн дохио
- Гүүр
- Аюулгүйн тойрог

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 13 -ны өдрийн А/12 дугаар тушаалын 03 дугаар хавсралт

# Ч:26 “ТООСГОНЫ ҮЙЛДВЭР – БОТАНИК – ЖАНЖИН КЛУБ”

Нийтийн Тээврийн Бодлогын Газар




## Тайлбар :

| | |
|---|---|
| Эргэлтийн урт: | 28.8 км |
| Эргэлтийн хугацаа: | 102 мин |
| Зогсох буудлын тоо: | 47 |
| Дайран өнгөрөх уулзварын тоо: | 7 |

- Жанжин клуб — Эцсийн зогсоол
- Сансарын ШТС — Хоёр чиглэлдээ зогсдог зогсоол
- 2-ын буудал — Нэг чиглэлдээ зогсдог зогсоол
- Хөдөлгөөний чиглэл
- Энхтайваны өргөн чөлөө — Гудамжны нэр
- 35° Газрын налуугийн градус /уруу/
- 35° Газрын налуугийн градус /өгсүүр/
- Гэрлэн дохио
- Гүүр
- Аюулгүйн тойрог

Нийтийн тээврийн газрын 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/12 дугаар тушаалын 04 дүгээр хавсралт

# Ч:29А "СЭЛБЭ АМРАЛТ - САНСАР - ХӨГЖИМ БҮЖГИЙН КОЛЛЕЖ – ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗАР"

**Нийтийн Тээврийн Бодлогын Газар**




## Тайлбар :

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Эргэлтийн урт: | 39,2 км | Сэлбэ амралт | Эцсийн зогсоол | 35° | Газрын налуугийн градус /уруу/ |
| Эргэлтийн хугацаа: | 126 мин | Сансарын ШТС | Хоёр чиглэлдээ зогсдог зогсоол | 35° | Газрын налуугийн градус /өгсүүр/ |
| Зогсох буудлын тоо: | 71 | Санктпетрбург | Нэг чиглэлдээ зогсдог зогсоол | | Гэрлэн дохио |
| Дайран өнгөрөх уулзварын тоо: | 11 | Хөдөлгөөний чиглэл | | | Гүүр |
| | | Энхтайваны өргөн чөлөө | Гудамжны нэр | | Аюулгүйн тойрог |